



НИЙСЛЭЛИЙН
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/51

Улаанбаатар хот

Журам батлах тухай

“Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль”-ийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, Нийслэлийн засаг даргын тамгын газрын 2015 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 03/418 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн засаг даргын 2015 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/69 дүгээр захирамжаар баталсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалт /Шилэн уулзалт/-д ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай журам”-ын дагуу “Албаны албан тушаалтнуудын иргэдтэй хийх хуваарьт уулзалтын журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Албан тушаалтнуудын иргэдтэй уулзах хуваарь”-ийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2.“Албан тушаалтнуудын иргэдтэй хийх хуваарьт болон бусад албан уулзалт хийх тусгай өрөө гарган тохижуулж бэлэн болгохыг ахлах нягтлан бодогч /ахмад Г.Болорцэцэг/, аж ахуйн дарга /хошууч Х.Чинбаатар/ нарт үүрэг болгосугай.

3.Албан тушаалтнуудын иргэдтэй хийх хуваарьт болон бусад албан уулзалтыг зохион байгуулах, дүн мэдээг нэгтгэн тайлагнах үйл ажиллагааг хариуцаж ажиллахыг өргөдөл гомдол бичиг хэргийн эрхлэгч, /ахлах дэслэгч О.Цэрэннадмид/-д даалгасугай.

4.Журамд хяналт тавьж, сар бүр танилцуулахыг дэд дарга, дэд хурандаа Ч.Оюунцэцэг/-т үүрэг болгосугай.

5.Журам батлагдсантай холбогдуулан албаны даргын 2013 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/66 дугаар тушаалаар баталсан “Иргэдээс албан тушаалтантай уулзах уулзалтын хуваарь”-ийг хүчингүй болгосугай.

Миний энэ тушаалыг нийт бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулсугай.

ДАРГА, ХУРАНДАА

Т.ЭНХБАТ

112015000143
2015 tushaal